

Үндэсний аудитын газрын харьяа
Хэнтий аймгийн Аудитын газар



ХЭАГ-2016/01-НА-ХЭ

**СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ӨӨРИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ТӨВЛӨРҮҮЛЭЛТ**

8/5/2016

Тайлан бэлтгэсэн Хэнтий аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Аудитын менежер: Б.Наранцэцэг Шинжээч: Б.Мөнгөнцэцэг 2016 оны 07 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147 тоот утсаар харилцана уу. Хаяг Хэнтий аймгийн Аудитын газар. Аймгийн ЗДТГ-ын байр. 325 тоот өрөө	Агуулга	
	Товчилсон үгийн тайлбар	
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	
	Ерөнхий мэдээлэл	
	Нэгдүгээр бүлэг: Соёл урлагийн байгууллагууд үйл ажиллагааны өөрийн орлогоо биелүүлэн ажиллажээ.	
	Хоёрдугаар бүлэг: Үйл ажиллагааны өөрийн орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан боловч удирдамж, төлөвлөгөө боловсруулагдаагүй байна.	
	Аудитын дүгнэлт	
	Аудитын зөвлөмж	
	Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн холбогдох байгууллагын санал	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгөх тайлбар	
	Аудитын тайлангийн баталгаажуулалт	

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧЛОСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
БСГ	Боловсрол Соёлын Газар
АДБ	Ардын дуу бүжиг
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

ТАНИЛЦУУЛГА, АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

Аудит хийх үндэслэл, шалтгаан

Аудитыг “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалт, аймгийн ИТХ-ын хүсэлт, Монгол улсын Ерөнхий Аудиторын “Төлөвлөгөө батлах тухай” 2016 оны 01 дүгээр сарын 13-ны А/05 тушаалын 2 дугаар хавсралтыг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Нийцлийн аудитын зорилго нь аймгийн Соёл урлагийн байгууллагууд 2015 онд өөрийн орлогыг бүрдүүлэхдээ хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа эсэхийг шалгаж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал, зөвлөмж боловсруулан аймгийн Боловсрол, соёлын газарт хүргүүлэх, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулахад чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- *Соёл урлагийн байгууллагын өөрийн орлогын бүрдүүлэлт*
- *Соёл урлагийн байгууллагын өөрийн орлогын бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналт*

Аудитын цар хүрээ

Аудитаар аймгийн Боловсрол Соёлын газар, Хан Хэнтий чуулга, Номын сан, Музей, Батноров, Баян-Адрага, Биндэр, Бор-Өндөр, Бэрх, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдын Соёлын төвүүдийн 2015 оны өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлт, болон орлого төвлөрүүлэхтэй холбоотой баримт материалыг хамруулан шалгалаа.

Аудитад дагаж мөрдсөн стандарт, арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн ба санхүүгийн аудитын журам, гарын авлагуудыг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудит хийгдсэн байгууллагын талаарх мэдээлэл

БСШУ-ны Сайдын багцад 1100890,9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас Соёлын үйлчилгээний салбарт тусгай зориулалтын шилжүүлгээр 42328,9 сая төгрөг, харьяа байгууллагын өөрийн орлогыг 3764.3 сая төгрөгөөр баталжээ.

Хэнтий аймгийн Боловсрол Соёлын салбарт 2015 онд нийт 25293.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас соёлын байгууллагуудад нийт 2077,3 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Соёлын салбарт батлагдсан төсвийн 1998,8 сая төгрөгийг тусгай шилжүүлгээр, үлдэх 78,4 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр байна.

2015 онд гүйцэтгэлээр 24825,7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос соёл урлагийн байгууллагуудад 1998,5 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Соёлын салбарын өөрийн орлогын төлөвлөгөөг 78,4 сая төгрөг байхаар төлөвлөснөөс 2015 онд орлогын гүйцэтгэл 66,6 сая төгрөг буюу 84,9 хувиар биелэгдэж, төлөвлөгөө 11,8 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

2015 онд Орон нутгийн номын сан, 12 сумын Соёлын төв өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 2,6 сая төгрөгөөр давуулан биелүүлж, Хан Хэнтий чуулга, Орон нутгийн музей, 5 сумын соёлын төв зэрэг соёл урлагийн байгууллагуудад өөрийн орлогын төлөвлөгөө нийт 9,2 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүндрэл бэрхшээл

Аймгийн БСГ болон Бор-Өндөр сум, Бэрх тосгоны соёлын төвүүд шаардлагатай нэмэлт баримт материалыг шаардсан хугацаанд гаргаж өгөлгүй хүндрэл учруулж байв.

Аудит хийсэн хугацаа:

Аудитын төлөвлөх үе шатны ажлыг 2016 оны 6 дугаар сарын 02-оос эхлэж, нэгдсэн тайлангийн төслийг 8 дугаар сарын 5-нд дуусгаж, холбогдох байгууллагаас саналыг авч, аудитын дүн, тайланг Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулав.

Аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатны ажлын гүйцэтгэх хугацаанд шинжээч Б.Мөнгөнцэцэг өвчтэй байснаас 18, үндэсний их баяр наадмын амралт 5 хоног нийт тайлангийн хугацаа 23 хоногоор хойшилсон ба өвчтэй байсан шинжээчийн ажлыг боловсон хүчний хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалан өөр аудитор шинжээчид хуваарилах боломжгүй байв.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын аудитын менежер Б.Наранцэцэг хянан удирдаж, стандартыг хангуулж, ахлах Аудитор Н.Туяа аудитыг зохион байгуулж, шинжээч Б.Мөнгөнцэцэг хийж гүйцэтгэлээ.

1. Соёл урлагийн байгууллагын өөрийн орлогын бүрдүүлэлт

•СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРИЙН ОРЛОГОО БИЕЛҮҮЛЭН АЖИЛЛАЖЭЭ

1.1. Соёлын байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа төсвийн зарчмыг хэрэгжүүлэх үүргээ бүрэн гүйцэтгээгүй байна.

Шалгуур:

Төсвийн тухай хуулийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах эсхүл зарлага нэмэгдсэнээ төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ” гэж заасан.

Нөхцөл байдал:

Хэнтий аймгийн Боловсрол Соёлын газраас аймгийн 2015 оны Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа 2014 оны орлогын гүйцэтгэлийг 5,8%-иар нэмэгдүүлэн тооцсон ба үүний дотор аудитад хамрагдсан байгууллагуудын орлогыг 3953,9 төгрөгөөр буюу 5,0%-иар нэмэгдүүлжээ.

д/д	Орлогын төрөл	Хүн ам	Үзэгчдийн суудлын тоо	2014 оны гүйцэтгэл	2015 оны төлөвлөгөө	Өсөлт /бууралт
1	Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга	-		26434,7	26393	-41,7
2	Аймгийн Нийтийн номын сан	-	-	70	48,9	-21,1
3	Орон нутгийн музей	-	-	1122,4	1955	832,6
4	Батноров сумын Соёлын төв	2252	300	2388,3	1800	-588,3
5	Баян-Адрага Соёлын төв	2418	200	1100,1	1600	499,9
6	Биндэр сумын Соёлын төв	3976	300	4643,7	3006	-1637,7
7	Бэрх тосгоны Соёлын ордон	2351	400	2823,8	5000	2176,2
8	Бор-Өндөр сумын Соёлын ордон	8576	280	15470,9	17900	2429,1
9	Өмнөдэлгэр сумын Соёлын төв	5521	250	1200	1200	0
10	Хэрлэн сумын Соёлын төв	21520	258	1095,7	1400	304,3
	Бүгд			56349,6	60302,9	3953,9

Зарим соёлын төв болон соёлын байгууллагууд үйл ажиллагааны өөрийн орлогыг өмнөх оноос бууруулсан ч соёлын салбарын орлогыг нийт дүнгээр 3,9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулжээ.

Бэрх тосгоны Соёлын ордон түрээсийн орлогын 20 хувийг төрийн санд авч, төсөвт суутган тооцоогүй, Бор-Өндөр сумын Соёлын ордны түрээсийн гэрээг шинэчлэн байгуулсан зэргээс шалтгаалан үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Илрүүлсэн асуудал ба түүний шалтгаан:

1. Хүн амын тоогоороо илүү олон, үзэгчдийн суудлын тоо ойролцоо Биндэр, Өмнөдэлгэр сумдын үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийг харьцуулж үзэхэд хүн ам багатай Биндэр суманд дахин илүү орлого олохоор төлөвлөсөн байгаа нь дээрх нөхцлүүдийг харгалзаж тооцдоггүйг харуулж байна.
2. Зарим сумдын соёлын төвүүд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэх төдий ажиллаж байгаа нь ажиглагдлаа.

Соёлын байгууллагуудад үйл ажиллагааны өөрийн орлогыг боловсруулахдаа үндэслэх батлагдсан норм норматив, аргачлал байдаггүйгээс үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулж төлөвлөдөг байна.

Үр дагавар ба нөлөө:

Соёлын байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг боловсруулахад зөвхөн өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэх нь хангалтгүй юм. Иймд орлогыг төлөвлөх тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, хууль тогтоомжид нийцүүлэн норм, норматив, аргачлал боловсруулах шаардлагатай байна.

1.2. Соёлын байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогын дийлэнх хувийг түрээсийн болон нийтийн бүжгийн орлогоос бүрдүүлж байна.

Шалгуур:

“Соёлын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт “Соёлын байгууллага нь улсын төсвийн болон бусад хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, хөнгөлөлттэй зээл, соёлын байгууллагын өөрийн орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна”.

Нөхцөл байдал:

Соёлын тухай хуульд заагдсан чиг үүргийн дагуу үндсэн үйл ажиллагаанаас өөрийн орлогоо бүрдүүлж байна.

Аймгийн хэмжээндэх соёл урлагийн байгууллагын мэргэжилтэй боловсон хүчний хангалт 71,5 хувьтай боловч түүний дотор соёлын төвүүдийн мэргэжилтэй ажилтны хангалт 56,8 хувийг эзлэж байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2015 оны орлогын бүрдүүлэлтийг үйлчилгээний төрлөөр нь харуулбал:

д/д	Орлогын төрөл	Тоглолт	түрээсийн	Нийтийн бүжгийн	Үзвэр үйлчилгээ	Бусад	Нийт
1	АДБ-ийн Хан Хэнтий чуулга	3541	10887,5	-	6134,7	220,5	20783,7
2	Аймгийн Нийтийн номын сан	-	-	-	-	50,0	50,0
3	Орон нутгийн музей	-	-	-	850,2	-	850,2
4	Батноров сумын Соёлын төв	724,5	-	518,5	512,4	46,0	1801,4
5	Баян-Адрага Соёлын төв	400,0	-	1217,6	150,0	50,0	1817,6
6	Биндэр сумын Соёлын төв	822,0	412,0	541,5	1203,5	27,0	3006
7	Бэрх тосгоны Соёлын ордон	1239	2612,4	28,5	861,1	259,1	5000,1
8	Бор-Өндөр сумын Соёлын ордон	176,7	15124,7	585,0	1190,1	336,9	17413,4
9	Өмнөдэлгэр сумын Соёлын төв	22,0	-	391,0	760,2	26,8	1200
10	Хэрлэн сумын Соёлын төв	-	-	1526,5	-	-	1526,5
	Бүгд	6925,2	29036,6	4808,6	11662,2	1016,3	53448,9

Хэрлэн, Баян-Адрага зэрэг сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааны өөрийн орлогын 67-100%-ийг нийтийн бүжгийн орлогоос бүрдүүлж байгаа бол АДБ-ийн Хан Хэнтий чуулга, Бэрх, Бор-Өндөр зэрэг томоохон соёлын төвүүд байр ашиглалт, тоглолтын хувцас болон техник хэрэгслийн түрээсийн орлогоор өөрийн орлогын 52,2-86,9%-ийг бүрдүүлжээ.

Илрүүлсэн асуудал ба түүний шалтгаан:

1. Соёлын төвүүдийн орлогын бүрдүүлэлтэд музейн үйл ажиллагаанаас орлого ороогүй бөгөөд Бэрх, Биндэр, Өмнөдэлгэр, Батноров, Баян-Адрага сумын соёлын төвүүдийг эс тооцвол номын сангийн үйл ажиллагаанаас орлого бүрдүүлээгүй байна.
2. Бэрхийн Соёлын ордны хувьд байрны талбай харьцангуй том учир урсгал зардал их гардаг. 2014 онд УТХО-ын 100,0 сая төгрөгийн хөрөнгөөр Соёлын төвийн байрыг засварлахдаа Цагдаагийн тасгийн зориулалтаар 2 өрөөг иж бүрэн зассан, гэтэл Цагдаагийн тасгаас соёлын төвийн байр ашигласны түрээс төлдөггүй байна.

Сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагаа харилцан адилгүй байгаа нь мэргэжлийн боловсон хүчний хангалт, тухайн ажилд хандах хандлагаас шалтгаалж байна.

Соёлын байгууллагын цалин бага, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж байгаа их дээд сургуулийн сургалтын чанар муугаас шалтгаалан шинээр төгсөн ирж байгаа залуучуудын чадвар ихээхэн сул байдаг талаар АДБ-ийн Хан Хэнтий Чуулгын даргын ярилцлагад дурдагдсан.

Үр дагавар ба нөлөө:

Тиймээс урлагийн байгууллагаас сургаж, дадлагажуулсан ажилтнуудад мэргэжил олгож ажиллуулах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Цаашид соёлын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, соёлын байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, сургах ажлыг анхааралдаа авч, шийдвэрлэх шаардлагатай болжээ.

1.3. Соёлын төвүүд үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллажээ.

Шалгуур:

“Төсвийн тухай” хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалт “ хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэгтэй”

Нөхцөл байдал:

Аймгийн хэмжээнд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 84,6 хувьтай биелсэн хэдий ч аудитад хамрагдсан байгууллагууд орлогын төлөвлөгөөгөө 101,1 хувиар биелүүлжээ.

/мян.төг/

д/д		Орлогын төлөвлөгөөний биелэлт								
		2013 он			2014 он			2015 он		
		төл	гүйц	хувь	төл	гүйц	хувь	төл	гүйц	хувь
1	АДБ-ийн Хан Хэнтий чуулга	21600	20336,7	94,2	26392,5	26434,7	100,2	26393	20783,7	78,7
2	Аймгийн Нийтийн номын сан	50,0	50,0	100	48,9	70,0	143,1	48,9	50,0	102,2
3	Орон нутгийн музей	2000	1901,2	95,1	1955	1122,4	57,4	1955	850,2	43,5
4	Батноров сумын Соёлын төв	2030	2159,8	106,4	1800	2388,3	132,7	1800	3001,4	166,7
5	Баян-Адрага Соёлын төв	1000	1010,5	101,1	1100	1100,1	100	1600	1817,7	113,6
6	Биндэр сумын Соёлын төв	1500	1500	100	6100	4643,7	76,1	3000	3006	100,2
7	Бэрх тосгоны Соёлын ордон	1300	3607,02	277,5	1500	2823,8	188,3	5000	5000,1	100
8	Бор-Өндөр сумын Соёлын ордон	5800	12579,1	216,8	17500	15470,9	88,4	17900	17413,4	97,3
9	Өмнөдэлгэр сумын Соёлын төв	1100	1100	100	1200	1200	100	1200	1200	100
10	Хэрлэн сумын Соёлын төв	800	803,2	100,4	900	1095,7	121,7	1400	1526,5	109
	ДҮН			129,2			110,8			101,1

Аудитад хамрагдсан соёлын байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө сүүлийн 3 жилийн байдлаар бүрэн биелсэн ба Батноров, Бэрх, Баян-Адрага, Өмнөдэлгэр, Хэрлэн сумд, Нийтийн номын сан зэрэг байгууллагууд нь үйл ажиллагааны орлогоо жил бүр биелүүлэн ажиллажээ.

Сумдын соёлын төвүүдэд номын сан, орон нутгийг судлах танхим ажиллаж байгаа боловч музейн үзмэр болон ном харьцангуй цөөн, баяжилт хийгдэхгүй байгаа зэрэг нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна.

Бор-Өндөр сумын хүн ам 8576 байхад номын тоо 1435 ширхэг, Хэрлэн сумын соёлын төвийн номын тоо 648 ширхэг, Өлзийт тосгон, Хэрлэн, Баян-овоо, Норовлин, Цэнхэрмандал зэрэг сумдад музейн үзмэргүй, Бэрх тосгоны соёлын төвд одоогийн байдлаар музейн үзмэрийг дээлэж, нийтийн хүртээл болгоогүй байна.

Илрүүлсэн асуудал ба түүний шалтгаан:

1. Орон нутгийг судлах музейн 2014 онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 2014 онд 57.4 хувь, 2015 онд 43,5 хувиар биелжээ.
2. 2014 оны 8-10 сард Сэцэн ханы ордон музейн 3 сүмд, 2015 онд музейн үлдсэн 2 сүмд мөн Орон нутгийг судлах музейд их засвар хийсний улмаас музей бүрэн ажиллаагүй. Үүний улмаас музейн орлого 2015 онд 56,5 хувиар тасарч, орлогын гүйцэтгэл 850,2 мянган төгрөг буюу 43,5 хувьтай байна.

Музейн үзмэрийг баяжуулах зардал 2013 оноос хойш төсөвт тусгагдахгүй болсноор музейд баяжилт хийх боломжгүй болж, орлого тасалдахад тодорхой нөлөө үзүүлж байна.

Үр дагавар ба нөлөө:

Музейн үзмэрийг баяжуулах, сэргээн засварлах, музейн ач холбогдол, үнэ цэнийн талаар хүүхэд залуучууд, иргэдэд таниулах ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлага чухлаар тавигдаж байна.

2. Соёл урлагийн байгууллагын өөрийн орлогын бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналт

- ЗАРИМ СОЁЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ ӨӨРИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ТӨВЛӨРҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

2.1 Санхүүгийн хязгаарлагдмал нөөц бололцоондоо тулгуурлан хууль тогтоомжид тусгагдсан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ.

Шалгуур:

Соёлын үйлчилгээг ард иргэдэд хүргэх үүргийг “Соёлын тухай” хуульд заасан ба тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1¹, 18.1.3², 18.2.2³, 18.2.3⁴ -д аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг заажээ.

Нөхцөл байдал:

Соёлын үйл ажиллагаанд соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа хамаарна.

¹ Түүх соёлын дурсгалт болон соёлын үнэт зүйлсийг хадгалах, хамгаалах

² Ажилчдын ерөнхий соёлын түвшинг дээшлүүлэх, урлаг, уран сайхны мэдрэмж, авьяас чадварыг хөгжүүлэх, соёлын үйлчилгээг сайжруулах

³ Жил бүрийн орлогын тодорхой хувийг соёлын зориулалтаар зарцуулах

⁴ Ажиллагчдын оюуны хэрэгцээг хангах зорилгоор соёлын үйл ажиллагаа эрхлэх нэгж байгуулах ажиллуулах

Илрүүлсэн асуудал ба түүний шалтгаан:

Соёл урлагийн байгууллагууд хуульд заагдсан чиг үүргээ тодорхой хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч санхүү, боловсон хүчний хангалт зэрэг нөхцөл байдал, шалтгааны улмаас бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

Хувцас болон материалын үнэ жилээс жилд нэмэгдэж байхад уран бүтээлийн зардалд зарцуулах өртөг хэвээр байгаа нь бодит байдалд нийцэхгүй байна.

Үр дагавар ба нөлөө:

Тиймээс мэргэжилтэй боловсон хүчнийг татах нөхцлийг бүрдүүлж ажиллах, уран бүтээлийн зардалд хүрэлцэхүйц хөрөнгө тусган батлуулж, түүнчлэн зардлыг улирал бүрт тэгшитгэн хуваарилдаг байдлыг өөрчлөн, шинээр уран бүтээл туурвих хөрөнгө, хугацааг шийдвэрлэх үүднээс уран бүтээлийн зардлыг улирал бүрт бус жилийн эхний улиралд бөөн дүнгээр хуваарилж өгөх нь зүйтэй юм.

2.2. Зарим соёлын байгууллагын төсвийн захирагч өөрийн орлогын бүрдүүлэлт болон төвлөрүүлэлтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шалгуур:

Аймаг, нийслэл сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, түүний хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлж, хяналтыг хэрэгжүүлэхээр,

- соёлын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг орон нутагт соёлын хяналтын байцаагч болон бүх шатны Засаг дарга хэрэгжүүлэхээр Соёлын тухай хуульд заасан.

Төсвийн орлогын бүрдүүлэлт төвлөрүүлэлтэд тавих хяналтын ажлын хүрээнд “Төсвийн тухай” хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1⁵, 41.2.3⁶-д бүх шатны төсвийн захирагч нарын төсвийн хэрэгжилтийн талаар хүлээх үүргийг заасан.

Нөхцөл байдал:

Аймгийн Боловсрол Соёлын газраас 2014 оныг хүртэл жил бүр сумдуудаа бүсчилэн хувааж, удирдамжийн дагуу ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ирсэн бөгөөд 2015 онд уг ажил хийгдээгүй байна.

Мэргэжлийн хяналтын газрын соёлын байцаагч төлөвлөгөөт хяналтын ажлын хүрээнд 2015 онд 3 сумын түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт хийж, 38 дугаартай хяналт шалгалтын танилцуулга бичсэн байна.

Соёлын байгууллагын нягтлан бодогч бэлэн мөнгө хүлээн авах болон орлого хүлээн авах маягт, билет зэргийг хэвлэн дугаарлаж, санхүүгийн болон байгууллагын тэмдэгээр баталгаажуулан няравт хүлээлгэн өгдөг ба орлогыг тухай бүр дансанд тушаалган, улирал бүр тооцоо бодож, үйл ажиллагааны өөрийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд хяналт тавин ажиллажээ.

⁵ Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

⁶ Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

АДБ-ийн Хан Хэнтий чуулга, аймгийн Музей, Бор-Өндөр сумын соёлын ордон зэрэг төсвийн захирагчийн зүгээс орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зарим сумдын соёлын төв орлогыг нэр төрлөөр нь биш “орлого”, “өөрийн орлого” нэрээр, хэд хэдэн орлогыг нийлүүлж бөөнөөр нь тушаасныг эс тооцвол орлогыг нэр төрлөөр нь төвлөрүүлжээ.

Орлогыг нийлүүлж, бөөн дүнгээр тушааснаар хэдэн хувь нь ямар үйл ажиллагаанаас бүрдсэн нь тодорхойгүй байна.

Орлогыг бөөнөөр тушаасан шалтгааныг тодруулахад банкны үйлчилгээний хураамж өндөр байдагтай холбоотойг тайлбарлаж байлаа. Үүнийг цаашид анхаарч, үйл ажиллагааны орлогын төрөл /утга/-өөр нь тушаалгах шаадлагатай байна.

Илрүүлсэн асуудал ба түүний шалтгаан:

Соёлын байгууллагаас хяналт шинжилгээ хийлгэж, бүх шатны Засаг дарга нараас соёлын талаар хяналт тавьсан ажлын тайлан, дүгнэлт, шийдвэр байхгүй байгаа нь хяналт тавьж ажиллаагүйг харуулж байна.

Аймгийн Боловсрол Соёлын газраас 2015 онд сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажил хийгдээгүй байна.

Үр дагавар ба нөлөө:

Хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөөгүйгээс үйл ажиллагаа нь тогтмол явж хэвшсэн нэр бүхий сумдын соёлын байгууллагуудыг эс тооцвол бусад нь тодорхой ахиц гарахгүй урсгалаараа явсаар байна.

2.3 Соёл урлагийн байгууллагууд өөрийн орлогоо бүртгэл тайланд үнэн зөв тусган ажиллажээ.

Шалгуур:

“Төсвийн тухай” хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалт “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” үүрэгтэй.

Нөхцөл байдал:

Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлого нь төсвийн орлогын санхүүжилтийн эх үүсвэрийн нэг бөгөөд аудитад хамрагдсан байгууллагууд 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа үйл ажиллагааны өөрийн орлогоо үнэ зөв тусгаж, тайлагнасан байна.

2.4 Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад санхүүгийн дэмжлэг шаардлагатай байна.

Шалгуур:

“Соёлын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт “соёлын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажилчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах”

Нөхцөл байдал:

Аймгийн Музейгээс ИТХ болон Засаг даргад хүсэлт тавьж аймгийн Засаг даргын нөөц сангаас 2013 онд 4,3 сая төгрөгийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, хуульд заасны дагуу хөрөнгө шийдвэрлүүлж, 2013-2015 онд дүрслэх урлагийн бүтээл, хувийн алдрын буланг нээн сан хөмрөгөө баяжуулсан байна.

Соёлын байгууллагын төсөв жил бүр өөрчлөлтгүй хэвээр батлагдаж байгаа бөгөөд соёлын салбарын асуудал анхаарлын гадна орхигдсоныг бүх соёлын байгууллагуудын удирдлага, ажилтнууд илэрхийлж байна.

Соёлын үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах, төсвийн зардлыг бодит байдалд ойртуулан төсөвт тусгуулах ажлыг шат шатандаа анхаарч, аймгийн соёлын байгууллагаас соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан бодлогоор дэмжих шаардлага байна.

Илрүүлсэн асуудал ба түүний шалтгаан:

Соёлын байгууллагуудын төсөв хүрэлцээ муутай, уран бүтээлийн зардал харьцангуй бага батлагддагаас томоохон уран бүтээл хийх болон тоног төхөөрөмж, тоглолтын хувцсаа шинэчлэх зэрэг асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаагаас элэгдэлд орж, хуучран, ашиглалтын шаардлага хангахгүй болжээ.

Тухайлбал: Бэрх тосгоны Соёлын төвд зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагааг үнэ төлбөргүй явуулж байгаа нь өөрийн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлтэд нөлөөлж байна.

Үр дагавар ба нөлөө:

Соёлын үйлчилгээг хуульд заагдсаны дагуу бүрэн дүүрэн хүргэх боломж хомс, төдий чинээгээр үйлчилгээний хүртээмж хангалттай бус, чанартай сайн уран бүтээл хийх боломж бүрдэхгүй байна.

Иймд Соёлын төвөөс зохион байгуулж буй зарим үйл ажиллагааг төлбөртэй явуулж өөрийн орлогыг бүрдүүлж ажиллах нь зүйтэй юм.

АУДИТЫН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлт:

- Соёлын байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа төсвийн зарчмыг хэрэгжүүлэх үүргээ бүрэн гүйцэтгээгүй байна.
- Соёлын байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогын дийлэнх хувийг түрээсийн болон нийтийн бүжгийн орлогоос бүрдүүлж байна.
- Соёлын төвүүд үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллажээ.
- Төсвийн захирагчаас өөрийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд тавьсан дотоод хяналт, хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажил, авсан арга хэмжээний дүн мэдээ байхгүй байна.

Аудитын зөвлөмж

Аймгийн Засаг дарга Н.Ганбямбад

- Соёлын байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлогын төлөвлөлтөд анхаарч, давсан орлогыг буцаан олгох асуудлыг шийдвэрлүүлэх

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Хэрлэнчимэгт

- Соёлын байгууллагын өөрийн орлогын төлөвлөлтөд анхаарч, орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг улирал тутам хийж, хэрэгжилтийг дүгнэж ажиллах

Аймгийн БСГ-ын дарга 3.Бат-Эрдэнэд

- Орлогын төлөвлөлтийг боловсруулах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, үйл ажиллагааны өөрийн орлогыг нэмэгдүүлэх нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах
- Урлагийн уран бүтээлийн зардлыг хүрэлцэхүйц хэмжээгээр батлуулах ажлыг зохион байгуулах.

Аудитын тайланд дурьдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ, зохион дүнгийн талаарх мэдээллийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор гаргаж албан бичгээр ирүүлнэ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛАГЫН САНАЛ

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал


**ХЭНТИЙ АЙМАГ
БОЛОВСРОЛ СОЁЛЫН ГАЗАР**
213700 Чингис хот, Хэрлэн сум
Утас: 70-56-36-40, Факс: 70-56-36-40
2016 09 19 № 269
Танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн 2016 оны 08 дугаар сарын 08-нд гаргасан аудитын дүгнэлт, зөвлөмжтэй танилцан зөвшөөрч байна.

Сумдын соёлын төвийн өөрийн орлогын төлөвлөлтийг хуваарилахдаа байгууллагын дунд хугацааны төсвийн төслийн саналын дагуу аймгийн ИТХ-аар батлуулдаг.

Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд уран бүтээлийн зардал боломжит хэмжээгээр тусгагдсан байдаг.

2016 оны сумдын соёлын төвийн төсвийн тодотгол ирсэнтэй холбогдуулан тухайн онд үүссэн өр, өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилготой асуудлыг судлан шийдвэрлэж байна.

ДАРГА  **З.БАТ-ЭРДЭНЭ**

*2016.09.19
Танайг албан ёсоор
холбогдох газруудад
иргүүлэх*

Ирүүлсэн саналд өгсөн аудиторын тайлбар

Шалгагдагч байгууллагаас аудитын тайланг хүлээн зөвшөөрсөн тухай албан бичиг ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН БИЧСЭН:

Шинжээч

Б.Мөнгөнцэцэг

2016 оны 08 дугаар сарын 05

ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 33

Өндөрхаан

Г Нийцлийн аудитын тайланг батлах тухай Т

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Нийслэл болон аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5. Гүйцэтгэлийн аудитын журам-ын 12.40, Чанарын хяналтын журам-ын 5.3.4, аймгийн Аудитын газрын удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Соёлын байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож, хариуцлага тооцох саналын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ц.ЭНХТҮВШИН